

**УБ ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙГ САЙЖРУУЛАХ II ДАХЬ ТӨСЛИЙН
ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН /2005/**

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	
Төслийн нэр	Улаанбаатар хотын Нийтийн Аж Ахуйг Сайжруулах 2 дахь Төсөл
Салбар	Нийтийн аж ахуй салбар
Төсөг хэрэгжих газар	Баянхошуу, Дарь-Эх-Дамбадаржаа, Чингэлтэй, Улиастай, Нарангийн гэр хорооллууд
Төслийг хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага	<p>Монгол улсын засгийн газар гэр хорооллын усан хангамжийг сайжруулах, стандартын шаардлагад нийцсэн чанартай усаар тасралтгүй хангахад чиглэсэн дэд бүтцийг хөгжүүлэхэд шаардагдах Хөрөнгө оруулалтын туслалцааг хүссэний дагуу Дэлхийн банк эхний шатны (УБНААСТ1) төслийн адилаар, хоёрдугаар шат болох УБНААСТ2 төсөлийг хэрэгжүүлэхэд зориулж 22.98 сая ам. Долларын хөнгөлөлттэй зээлийг олгосон юм.</p> <p>Усны салбарт хэрэгжүүлэх төслийн гол асуудлууд нь: а/ гэр хорооллын НАА-н үйлчилгээг сайжруулах зайлшгүй шаардлага; б/ хотын төвлөрсөн сүлжээн дэх усны алдагдлыг багасгах; в/ үнэ тарифийн шинэчлэл хийх замаар усны нөөцийг хамгаалах; г/ зардлыг багсгах, зардлаа бүрэн нөхөх замаар салбарын санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэхэд оршиж байгаа юм. Мөн ус хангамжийн үр ашигтай байдал, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, хот төлөвлөлт, газар зохион байгуулалт, НЗДТГ-ын удирдлага, санхүүжилт зэрэг чухал шаардлагатай хэсгүүдэд хөрөнгө оруулалтыг хийх замаар хот байгуулалтын ач холбогдолыг нэмэгдүүлнэ.</p>
Төслийн зорилго	Төслийн тэргүүн зэргийн зорилго нь “Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчдад стандартын шаардлагад нийцсэн ус хангамжийн үйлчилгээг хүргэх, найдвартай, тогтвортой болгох”
Төслийн хүрээнд хийгдэх ажлууд	<p>Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төсөл 2004-2009 онд хэрэгжих бөгөөд төслийн нийт өртөг 22.98 сая ам.доллар. Гэрээний дугаар: 3890-МОГ, Төсөлд дараахи гэр хорооллууд хамрагдана.</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Чингэлтэй /Чингэлтэй дүүрэг/ <input type="checkbox"/> Дамбадаржаа /Сүхбаатар дүүрэг/ <input type="checkbox"/> Баянхошуу /Сонгино Хайрхан дүүрэг/ <input type="checkbox"/> Дарь-Эх /Баянзүрх дүүрэг/ <input type="checkbox"/> Наран /Баянгол дүүрэг/ <input type="checkbox"/> Улиастай /Баянзүрх дүүрэг/ <p>Төсөл 4 бүрэлдэхүүн хэсэгтэй.</p> <p>1. <u>Гэр хорооллын ус хангамж</u></p> <p>(1) 78.2 км орчим шугам хоолойг ханган нийлүүлж, суурилуулах; Үүнээс Баянхошууд 39 км, Чингэлтэйд 13км, Дамбадаржаа-Дарь-эхэд 20.1км, нийт 72.1км шугам хоолой, одоо байгаа 81 УТБ-ыг шинээр 25 УТБ-ыг хотын сүлжээнд холбоно.</p> <p>(2) 2 усан, 3 насосны станц шинээр барьж, 111 ус түгээх байрыг шинээр барих ба засварлана. Эмнэлэг,</p>

	<p>сургууль зэрэг 17 байгууллага, 430 айл өрхийг цэвэр усны шугамд холбох</p> <p>(3) 10,000 орчим усны тоолуур, усны янз бүрийн насосуудыг холбогдох цахилгаан тоног төхөөрөмжийн хамт ханган нийлүүлж, суурилуулах;</p> <p>(4) 15 ус зөөврийн машин, бохирын 5 машин, тэдгээрийн сэлбэг хэрэгслийг ханган нийлүүлнэ.</p> <p>2. <u>Хотын ус хангамжийг сайжруулах</u></p> <p>(1) Хотын шугам сүлжээний 12.2 км урт яндан хоолойг солино.;</p> <p>(2) Баруун дүүргийн насосны станцыг 4 насос, тоног төхөөрөмжийг сайжруулах; Усан хангамжийн телеметрийн системийг сайжруулах; Сэлбэг хэрэгсэл болон лабораторийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх.</p> <p>3. <u>Эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх</u> Гүний 90 орчим насос; Дээд эх үүсвэрт 1,000 киловатын трансформатор болон хяналтын систем; Дээд, Төвийн, Мах комбинатын эх үүсвэрүүдэд 59 км агаарын шугамыг тус тус ханган нийлүүлж суурилуулна.</p> <p>4. <u>Зохион байгуулалтыг боловсронгуй болгох ба Төслийн менежмент</u></p> <p>(1) Инженерийн нарийвчилсан зураг төсөл хийх, сонгон шалгаруулалтын бичиг баримт бэлтгэж, сонгон шалгаруулалтыг явуулах; барилгын ажлын хяналт, менежмент, чанарын хяналт хийх Зөвлөхийн үйлчилгээ</p> <p>(2) Бодлогын хүрээнд: олон нийттэй харилцах; санхүүгийн дотоод хяналт; айл өрхийг шугамд холбож, тоолууржуулах; ариун цэврийн байгууламж; УТБ болон зөөврийн ус хангамжид хувийн секторын оролцоо; эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх; үйл ажиллагааны зардлыг багасгах зэрэгт Зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх</p>
<p>Төслийн үр ашиг, үр дүн</p>	<ul style="list-style-type: none"> • Гэр хорооллын нөхцөл сайжирч ирээдүйд АОС болон хөгжих нөхцөл бүрдэнэ. • УСУГ-ын үйл ажиллагаа, менежментийн хүчин чадлыг бэхжүүлнэ. • Хувийн секторын оролцоо нэмэгдэнэ • Шугам сүлжээн дэх усны алдагдал буурна. • Цахилгаан эрчим хүчийг хэмнэнэ. • Усны хүрэлцээ, шугам сүлжээний найдвартай байдлыг сайжруулна. • Айл өрх, байгууллагууд ус хангамжийн системд холбогдоно. • Орон сууцны болон гэр хорооллуудын нийтийн аж ахуйн үйлчилгээний ялгаа багасна. • Ус түгээх байруудыг хувьчилна.

	<ul style="list-style-type: none"> • Хотын ядуурлын хүрээг багасгаж, амьдралын нөхцөлийг сайжруулна. • Олон нийтийн оролцоо үүргийг нэмэгдүүлнэ. • Гэр хорооллын болон хотын барилгажсан хэсгийн хэрэглэгчдийн усны төлбөрийн ялгаа багасна. • Ундны усны дутагдал арилна. • Гэр хорооллын уснаас үүдэлтэй өвчнөөр өвчилсөн оршин суугчдын эзлэх хувь буурна. • Хүүхдийн эрүүл мэнд сайжирна. • Шугам сүлжээнд холбогдсоноор өртөг зардал өндөртэй, ажиллагаа ихтэй зөөврөөр ус зөөх асуудал багасна.
<p>Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ (сая ам. доллар)</p>	<p>Олон улсын хөгжлийн ассоциаци-18 сая ам. доллар НЗДТГ-0.57 сая ам. доллар УСУГ-4.41 сая ам.доллар</p> <p>Бүгд: 22.98 сая ам.доллар</p>
<p>Төслийн хууль эрх зүйн орчны бүрдэлт</p>	<p>Төслийг удирдах нэгж төслийн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, зээл хүчин төгөлдөр болох үндсэн нөхцөлүүдийг хангахад анхаарал тавьж ажилласан.</p> <p>Монгол улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд Хөгжлийн зээлийн гэрээг 2004 оны 7-р сарын 23-нд байгуулж, Улсын их хурлаар 2004 оны 10-р сарын 22-ний өдөр соёрхон батлагдаж хуульчлагдсан юм.</p> <p style="text-align: center;">❖</p> <p>Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол 2004 оны 11-р сарын 01-ний өдөр гарч НЗДТГазар болон Дэлхийн банкны ОУА-ийн хооронд байгуулсан Төслийн гэрээг баталж, Засгийн газар болон НЗДТГ-ын хооронд, мөн НЗДТГ болон УСАГ-ын хооронд ОУХА-ийн шаардлагад нийцсэн нөхцөлөөр дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулах үүргийг Хотын захирагчид даалгасан юм.</p> <p style="text-align: center;">❖</p> <p>2004 оны 11-р сарын 04-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх тухай ДЗГэрээнд гарын үсэг зурах эрх батламжлагдав.</p> <p style="text-align: center;">❖</p> <p>Энэ хугацаанд дээрх 2 дамжуулан зээлдүүлэх гэрээний нөхцлүүдийг 5%-ийн зээлийн хүүтэй 10/40 жилийн хугацаатай байхаар гэрээнд тусгасан юм. Мөн НААС эхний төслийн ДЗГэрээний хугацаа нь 5/20 байсныг 10/40 жил болгох тухай хүсэлтийг хотын дарга Дэвид Долларт тавьж шийдвэрлүүлсэн юм.</p> <p style="text-align: center;">❖</p> <p>Зээлийн хөрөнгийг зарцуулах нөхцлийн нэг нь УСУГ-ын санхүүгийн хүчин чадал зээл эргэн төлөх хэмжээний чадвартай байх асуудал бөгөөд энэ зорилгын үүднээс усны үнэ тарифыг нэмэгдүүлэх арга хэмжээг зайлшгүй авах асуудал байсан. Энэ асуудлыг 2004 оны 11-р сараас эхлэн ОУХА, УСУГ, ТУН-ээс удаа дараа тавьж байгаа бөгөөд энэ асуудал нь Монгол улсад өрнөсөн олон нийтийн сонгууль (2004 оны 6-р сарын 27), иргэдийн төлөөлөгчдийн хурал байгуулагдах процесс, Ерөнхийлөгчийн</p>

	<p>сонгууль (2005 оны 5-р сарын 22) зэрэг улс төрийн шалтгааны улмаас хойшилсоор байв. Хэдийгээр усыг олзворлох, боловсруулах, түгээхэд шаардагддаг эрчим хүч, шатах тослох материал, болон бусад хэрэглээний үнэ тариф нэмэгдсэн ч усны үнийг нэмэхгүй барьсаар байв.</p> <p style="text-align: center;">❖</p> <p>2005 оны 7-р сарын 15-ны өдрийн 1/1286 тоот захирамжаар НЗД-ын зөвлөмж гарч усны үнэ тарифийг шинэчлэн 2005 оны 9-р сарын 1- ээс эхлэн нэмэгдүүлэхээр болов. Усны шинэчилсэн үнэ тарифийг 2005 оны 9-р сарын 1-нээс эхлэн усны төлбөр тооцоонд ашиглаж эхлэв.</p> <p style="text-align: center;">❖</p> <p>Усны үнэ тариф нэмэгдсэн нь Төслийн хөрөнгийг зарцуулах гэрээний нөхцөл бүрдэж буй тул Дэлхийн банк 2005 оны 11-р сарын 29-ны өдөр зөвшөөрөл гарч УБ хотын НААС 2 дахь төслийн хөрөнгийг захируулах эрх нээгдсэн.</p> <p style="text-align: center;">❖</p> <p>УСУГ-ын санхүүгийн хүчин чадлыг бэхжүүлэх, 2 дахь төслийг хэрэгжүүлэхэд санхүүгийн хувьд бие даасан байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 1-р төслийн ДЗГ–ний нөхцлийн дагуу төлбөл зохих зээлийн эргэн төлөлтийн 2004, 2005 онуудад ноогдож байгаа төлбөрийг 2 жилээр хойшлуулах тухай УСУГ-ийн хүсэлтийг НЗДТГ, Сангийн яам хүлээн авч судлан боломжтой гэж үзсэн бөгөөд Засгийн газрын шийдвэрийг гаргуулахаар ажиллаж байна.</p>
<p>Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө</p>	<p>Гэр хорооллын ус хангамжийн системийг сайжруулснаар шууд ба шууд бус хэд хэдэн эерэг нөлөөллийг байгаль орчинд үзүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Усны асуудлыг сайжруулснаар эрүүл мэндийн асуудалд ихээхэн үр ашигтай болох бөгөөд түүнийг тоогоор илэрхийлэх аргагүй юм. • Төсөл хэрэгжүүлэх гэр хорооллуудын УТБ-дад зөврөөр бус шугамаар ус очиж ус хангамжийн үйлчилгээ ихээхэн сайжирч, ялангуяа ус хангамжийн найдвартай байдал сайжрах юм. • Баталгаатай ундны ус хэрэглэх боломж нэмэгдэж, улам найдвартай болно. • Ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой өвчин багассанаар хувь хүний болон гэл бүлийн ариун цэвэр, эрүүл ахуй сайжирч, улмаар хүмүүсийн амьдралын чанар сайжрах юм. • Нийтийн аж ахуйн үйлчилгээ сайжрах нь цаг хөдөлмөр хэмнэх боломж олгох бөгөөд ингэснээр ялангуяа эмэгтэйчүүдийн орлого нэмэгдэх боломжийг олгоно.
<p>2005 онд Дэлхийн банкны үндсэн зээлийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд</p>	<ul style="list-style-type: none"> • 2004 онд “Нарийвчилсан зураг төсөл боловсруулах” зураг төсөл-Зөвлөхийн баг шалгарч ажлаа эхлэн, 2005 оны 12-р сарын эхээр зургийн эхний ээлжийг дуусган улсын экспертизээр өгөөд байна. • Холбогдох яам, НЗДТГ, Захирагчийн ажлын албадаас бүрдсэн Төслийг удирдах хороог байгуулж, төслийн хүрээнд хийгдэж байгаа ажлуудтай танилцуулж, гарч буй хүндрэлүүдийг хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцох уулзалтыг 3 удаа зохион байгуулав. • Улаанбаатар хотын Ерөнхий инженер, Инженерийн

	<p>байгууламжийн хэлтсийн даргаар ахлуулсан мэргэжлийн хэсгийг байгуулан ажлын зургийг боловсруулах шатанд гарч буй техникийн зарим асуудлыг шийдвэрлүүлж байв.</p> <ul style="list-style-type: none"> • Ашиглагч байгууллага болох УСУГ-ын дэргэд төслийг хэрэгжүүлэх нэгж /ТХН/ байгуулан 7 хоног тутмын 5 дахь өдөр ТУН, ТХН, Зөвлөх багийн уулзалтыг зохион байгуулан, урд 7 хоногт гүйцэтгэсэн ажлаа тайлагнан дараагийн ажлаа төлөвлөх замаар ажиллаж байв.
<p>2005 онд Буцалтгүй тусламжуудаар хийгдсэн ажлууд</p>	<p>Дэлхийн банкны усан хангамжийн үндсэн зээлийг даган хэд хэдэн буцалтгүй тусламжууд орж ирсэн бөгөөд бүгд Сангийн Яамтай гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Голландын буцалтгүй тусламж (Итгэлийн сан) TF 054416</p> <p>Монгол улсын Засгийн газар нь Олон улсын хөгжлийн ассоциаци, Голландын засгийн газраас буцалтгүй тусламж авч байгаа бөгөөд энэ тусламжийг “Монгол орны хүрээлэн байгаа орчныг шинэчлэх”-төслийн хүрээнд Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын далан сувгийн ажил, ногоон байгууламж, мод үржүүлгийн газрын өргөтгөл шинэчлэлт, гэр хорооллын хашаанд жимсний мод бут суулгах ажлуудыг дэлхийн банкны дүрэм журамд нийцүүлэн хийхээр төлөвлөсөн юм.</p> <p>Буцалтгүй тусламжийн хэмжээ нь 1,850,000 ам. доллар бөгөөд 2005 оны 4-р сарын 4-нд Олон улсын хөгжлийн ассоциаци, Сангийн яамны хооронд гэрээ байгуулсан юм.</p> <p>Гэрээнд гарын үсэг зурагдахаас өмнө бэлтгэл ажлыг хангах зорилгоор доорх ажлууд хийгдлээ.</p> <ul style="list-style-type: none"> • Үзүүлж байгаа тусламжийн зорилго чиглэл, өртгийн хэмжээнд тохирсон Улаанбаатар хотын гэр хороололд нэн даруй шаардагдаж байгаа ажлуудын судалгааг гаргав. • БОЯ, НЗДТГ, Нийслэлийн хот тохижилтын газар, инженерийн байгууламжийн хэлтэс зэрэг энэ ажилд шууд хамаатай оролцогч талуудын санаа бодлыг судлав. • Дээрх судалгаанууд дээр үндэслэн төлөвлөж байгаа ажлын жагсаалтуудыг гаргаж, өртгийг тогтоон, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зохиож Дэлхийн банкаар батлуулав. • Далан суваг, халуун усны барилгуудын ажлын зураг төслийг зохиолгохоор зургийн даалгавар өгч, ногоон байгууламжийн ажлын хэмжээг тогтоолгож шаардагдах схем, төслийг гаргуулав. • 2005 оны 4-р сарын 4 гэрээнд гарын үсэг зурав. Гэрээнд гарын үсэг зурагдмагц өмнө эхэлсэн байсан ажлуудаа баталгаажуулж, гэрээ хэлцэл байгуулах, ажлын зургуудаа эцэслэх, дүүргүүдийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, хийхээр төлөвлөж буй ногоон байгууламжийн ажилд нь чиг

	<p>өгөх зэрэг ажлуудыг хийв.</p> <ul style="list-style-type: none">• Хотын тендерийн хороог байгуулж, зураг, төсөл, Ногоон байгууламжийн ажилд зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх Зөвлөх компанийг шалгаруулж зөвлөмж гаргуулах, үүнийгээ Дэлхийн банкинд явуулав.• Улаанбаатар хотод ногоон байгууламжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай уулзалт зохион байгуулав.• Яам дундын тендерийн хороо, Улаанбаатар хотын тендерийн хороог байгуулж 9 гэрээт ажилд дотоодын сонгон шалгаруулалтыг явуулж гүйцэтгэгчийг тодруулав.• Гэрээт ажлууд цаг хугацаандаа амжилттай хэрэгжин Хотын баярын өмнө 5, мөн улс тунхагласны баярын өмнө бусад ногоон байгууламжийн ажлыг тус тус ашиглалтанд өгөв. (Хавсралт1),• Далан суваг, халуун усны барилга, зам гүүрийн ажлууд графикайн дагуу хийгдэж байгаа бөгөөд одоогоор өвлийн бэлтгэл ажлаа хангаад байна.• Нийт ажлын хэрэгжилтийн явцыг /хавсралт 2/-оос харна уу?
	<p>2. Японы нийгмийн хөгжлийн сангийн хүрээнд:</p> <p>Монгол улсын Засгийн газар нь Олон улсын хөгжлийн ассоциаци, Японы нийгмийн хөгжлийн сан (ЯНХС)-аас буцалтгүй тусламж авч байгаа бөгөөд энэ тусламжийг олон нийтэд түшиглэсэн дэд бүтцийг хөгжүүлэх, айл өрхийн хашаанд хямд өртөгтэй ариун цэврийн байгууламжийг барихад зарцуулахаар шийдвэрлэсэн бөгөөд гэрээ нь 3 жилийн хугацаанд хэрэгжинэ.</p> <p>Гэрээт дүн нь 1,892,100 ам доллараас хэтрэхгүй байхаар төлөвлөгдсөн.</p> <p>Төслийн зорилго нь Улаанбаатар хотын сонгогдсон гэр хорооллуудын дунд олон нийтэд түшиглэсэн дэд бүтцийг хөгжүүлэх, айл өрхийн хашаанд хямд өртөгтэй ариун цэврийн байгууламжийг барих замаар ядуу иргэдийн амьдралыг дэмжихэд Монгол улсын Засгийн газарт тусламж дэмжлэг үзүүлэхэд оршиж байгаа юм.</p> <p>Төсөл 3 хэсгээс бүрдэнэ.</p> <ul style="list-style-type: none">a. А хэсэг. Иргэдийн оролцоотойгоор гэр хороололд орчноо хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулахb. Б хэсэг. Гэр хорооллын ядуу иргэдэд хямд

зардлаар жорлонгоо сайжруулахад туслах

с. В хэсэг. Үнэлгээ ба хяналт

УБ хотын НААС хоёр дахь ТУН нь энэ төслийг хэрэгжүүлэх бөгөөд 2005 оны 7-р сараас эхлэн 2008 оны 12-р сар хүртэлх ажлаа төлөвлөн үйл ажиллагаагаа явуулж байна. УБ хотын НААС төслийн хүрээнд сонгогдсон 6 гэр хорооллын дунд (22 гэр хороолол байдаг) энэ төслийг хэрэгжүүлж иргэдийн өөрсдийн санаачлагаар олон нийтийн байгууллагуудыг байгуулж, тэдгээр нь хүрээлэн байгаа орчноо, ариун цэврийн байгууламжаа сайжруулах, улмаар идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг болгохыг зорьж байна.

Одоогийн байдлаар ТУН дараах ажлуудыг хийлээ.

- Энэ төслийн хүрээнд хийгдэх ажлын удирдамж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажлыг 2005 оны 4-р сараас эхлүүлэв
- Олон нийтэд тулгуурласан дэд бүтцийг хөгжүүлэх, бичил зээл олгох, иргэдийн дунд бичил банк санхүүгийн байгууллага байгуулах болон бусад олон асуудлаар Дэлхийн банкны төлөөлөгч Барат Дахия, мөн ЮНЕСКО-ийн зөвлөх Хенри Брайнэс нарын лекцийг сонсож Монгол хөгжүүлэх боломжийн талаар ярилцав.
- Мөн Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа Дэлхийн зөн олон улсын байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрийн тусламжаар байгуулагдсан 2 ТББ-тай уулзаж туршлага судалж, иргэдтэйгээ явуулж байгаа уулзалтанд нь оролцов.
- Энэ ажлын талаарх зөв ойлголт чиг хандлагыг өгөх зорилгоор хороодын засаг дарга нартай, дүүргийн засаг дарга нартай уулзалт зохион байгуулав.
- Мөн БХБЯ, НЗДТГ болон бусад холбогдох байгууллагын удирдлагуудтай Дэлхийн банкны төлөөлөгчийг байлцуулан уулзалтуудыг зохион байгуулав.
- Энэ төслийн зохицуулагчийг шалгаруулж ажилд нь оруулав.
- Дэлхийн банкнаас энэ ажлыг эхлүүлэх, гэр хорооллын айл өрхийн эрүүл ахуй, ариун цэврийг хөгжүүлэхэд Монгол оронд юу хийж болохыг тодорхойлох зорилго бүхий 3 Зөвлөх /Henry Brionos, Santanu Lahiri, Ишбалжир/ нарыг 23 хоногийн хугацаатай томилон ажиллуулав.
- Эдгээр зөвлөхүүд 3 үе шаттай арга хэмжээ зохион байгуулсан. 1. Гэр хорооллын ариун цэвэр, эрүүл ахуйн асуудлууд сэдэвт үндэсний зөвлөлдөх

	<p>семинар зохион байгуулав. Энэ семинарт Монголд үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын донор орнуудын төлөөлөгчид, яам, хотын удирдах ажилтнуудыг оролцуулав 2. Дүүрэг, хороодын засаг дарга нартай энэ сэдвээр мөн уулзалт семинар хийв. 3. Нийслэлийн 6 гэр хорооллоос Сонгинохайрхан дүүргийн иргэдийн янз бүрийн давхрагыг сонгон авч ярилцлага хийн, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулав.</p> <ul style="list-style-type: none">• Зөвлөхүүдийн боловсруулсан Монгол орны гэр хорооллын ариун цэвэр, эрүүл ахуйн асуудлаарх зөвлөмж, гарын авлага, сургалтын материалыг хот, дүүргийн холбогдох газруудад явуулж санал зөвлөмж авав.• Иргэдийн оролцоотойгоор амьдарч буй орчноо хөгжүүлэх ажлыг эхлүүлэхэд шаардагдах ажлын удирдамжийг зохиох үүрэг бүхий Дотоодын Зөвлөхийн багийг шалгаруулах тендер зарлагдан 7 байгууллага саналаа ирүүлснээс 1-ийг шалгаруулж дэлхийн банкнаас зөвшөөрөл авахаар явуулаад байна.
	<p>3. Францын засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд:</p> <p>Улаанбаатар хотын НЗДТГ-нь Францын Засгийн газраас Улаанбаатар хотын цэвэр, бохир усны мастер төлөвлөгөөг ирэх 15 жилд буюу 2020 оны хэмжээнд боловсруулах ажилд санхүүгийн тусламж үзүүлээч гэж хүссэн юм.</p> <p>Францын засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд Улаанбаатар хотын цэвэр, бохир усны мастер төлөвлөгөөг зохиох ажил хийгдэх бөгөөд энэ төслийг Францын Сеурика компани хийж гүйцэтгэж байна.</p> <p>Сеурика компаний төлөөлөгчид Монголд ирж холбогдох яам, тамгын газартай уулзалтууд зохион байгуулж, УСУГ, НЗДТГ-аас гэрээнд болон ажлын удирдамжинд өгч байгаа санал зөвлөмжийг цуглуулж, гэрээ хэлэлцээр байгуулах ажлын бэлтгэлийг хангав.</p> <p>2005 оны 4-р сарын 18-нд Францын элчин сайд, Сеурика компаний төлөөлөгчид НЗДТГ-тай гэрээнд гарын үсэг зурснаар төсөл хүчин төгөлдөр болсон юм.</p> <p>Сеурика компани гэрээний дагуу ажилдаа орж 2005 оны 4-р сарын 18-аас эхлэн судалгааны ажлаа хийж эхлэв.</p> <p>2005 оны 8-р сарын 1-нд төслийн удирдах хороог байгуулав.</p> <p>2005 оны 8-р сарын 12-нд төслийн удирдах хорооны анхны хуралдааныг хийж эхлэлийн тайланг танилцуулав.</p>

	<p>Зөвлөхийн баг нь нийслэлийн цэвэр бохир усны байгууламжийн өнөөгийн байдал, усны эх үүсвэр, тэдгээрийг хамгаалж байгаа байдал, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээ, гэр хорооллыг хэрхэн хөгжүүлэх бодлогын асуудалд мастер төлөвлөгөөг хэрхэн уялдуулах зэрэг болон бусад асуудлуудтай холбогдох баримт бичгүүдийг цуглуулах, судлах, үнэлэлт дүгнэлт өгөх ажлуудыг УСУГ, ТУН болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байна.</p> <p>2005 оны 11-р сарын эхээр Улаанбаатар хотын БХБЯ, НЗДТГ, Захирагчийн ажлын алба, УСУГ болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудын дунд уулзалт зохион байгуулж хотын хөгжлийн хэтийн төлөв, өнөөгийн байдал, ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад гарч буй хүндрэлүүд, гэр хорооллыг хэрхэн цэвэр, бохир усанд холбох бодлогын асуудлуудын талаар санал бодлоо чөлөөтэй хэлэлцэв.</p> <p>Дунд шатны тайлангаа Англи Монгол хэл дээр боловсруулан гаргаж холбогдох яам, тамгын газар руу санал авахаар хүргүүлсэн.</p>
	<p>4. Нийслэлийн санхүүгийн чадавхи, хүний нөөцийн удирдлагыг сайжруулах төслийн ажлын хүрээнд:</p> <p>Энэхүү төслийн зорилго, бүрэлдэхүүн хэсэг нь УБ хотын НЗДТГ түүний харъяа байгууллагуудын санхүүгийн хүчин чадлыг бэхжүүлэхэд шаардагдах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, хүний нөөцийн удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хот, нийслэлд шаардагдах тоног төхөөрөмжөөр хангах, ажилтнуудыг сургалтад хамруулах, бизнес аялал зохион байгуулах гэсэн үндсэн хэсгүүдтэй.</p> <p>Дэлхийн банкны төлөөлөгч болох Дэвид Ай, Шабих нарын удирдлагын дор төслөөр хийгдэх ажлын удирдамж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэн гаргаж баталгаажуулав.</p> <p>Улаанбаатар хотын санхүүгийн чадавхи, хүний нөөцийн удирдлагыг сайжруулах ажлын хүрээнд олон улсын нээлттэй тендер зарлаж нийт 20 байгууллага саналаа ирүүлэв. /Хавсралт3/</p> <p>Эдгээрээс 6 байгууллагыг богино жагсаалтанд оруулж мэдэгдлийг хүргүүлэв.</p> <p>2005 оны 8-р сарын 9-нд хотын тендерийн хороог байгуулав.</p> <p>Уг төслийн хүрээнд худалдан авах тоног төхөөрөмжийн судалгааг гарган, ханган нийлүүлэгч байгууллагуудын үнийн саналыг авч харьцуулалт хийж 1 ханган нийлүүлэгчийг сонгож шаардлагатай тоног төхөөрмжийг</p>

	<p>хотод нийлүүлэв.</p> <p>Дээрх төслийг хэрэгжүүлэхээр саналаа ирүүлсэн 6 зөвлөх компаниас 1 –ийг сонгохын тулд хийх ажлын удиодамж үнийн саналыг авах хугацаатай тендер зарлаад байна. Тендерийн саналыг авах эцсийн хугацаа 2006 оны 1-р сарын 26 бөгөөд одоогийн байдлаар 2 байгууллага нэрээ татаж аваад байна.</p>
<p>Зээл, тусламжийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэлүүд</p>	<p>Төсөл хэрэгжилтийн явцад доорхи хэд хэдэн хүндрэлүүд гарч байв.</p> <ol style="list-style-type: none"> 1. Улс төрийн шалтгаан-Тус улсад дөрвөн жил тутамд болдог олон нийтийн сонгууль нь төслийн эхлэлийн үе шаттай давхацсан нь зээлийн гэрээ, төслийн гэрээ, дамжуулан зээлдүүлэх гэрээнүүд болон бусад хууль эрх зүйн асуудлууд бүрдэхэд, мөн нарийвчилсан зураг төсөл эхлэх хугацаа зэрэгт нөлөөлсөн. Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орж зарим яам, агентлаг шинээр байгуулагдсаны нэг нь БХБЯ байлаа. Шинээр байгуулагдсан БХБЯ-ны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь Засгийн газрын “40-50 мянган айлын орон сууцыг барьж байгуулах” мөрийн хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын бохир усны асуудлыг шийдэх асуудал байсан. Энэ зорилгоор төслийн үндсэн бүтцийг өөрчлөх, айл өрхийг цэвэр, бохир усны шугамд холбоход чиглүүлж төслийн судалгааг дахин хянаж үзэхийг даалгасны дагуу усны 1хүний хэрэглээг нэмэгдүүлсэн байдлаар тооцоо судалгаа хийж өөрчилсөн. 2. Бусад хүчин зүйлийн нөлөөлөл-Нарийвчилсан зураг төслийн хүрээнд инженер хайгуул, геодезийн судалгааг бүх трассын дагуу хийлгэх зайлшгүй шаардлага гарсан. Энэ асуудлыг ICT компаний гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх асуудлыг холбогдох газруудаар хэлэлцэж шийдвэр гаргуулахын тулд мөн 3 сар зарцуулж байв. 3. ТУН-нь хэдийгээр 1-р төслийн үргэлжлэл болох 2 дахь төслийг хэрэгжүүлэх арвин туршлагатай ч хуучин ажиллаж байсан зарим ажилтнууд нь өөр төслүүдэд шилжсэн нь /өндөр цалинтай ажил хийхээр/ шинээр авсан ажилтнуудаа /тухайлбал сонгон шалгаруулалтын бичиг баримт боловсруулах/ дахин сургах, дадлагажуулах, бэлтгэх зайлшгүй шаардлагатай нь харагдаж байв. 4. Тендерийн хуулийн босго үнийн шаардлагаар яам дундын тендерийн хороо байгуулагдаж хэд хэдэн тендер шалгаруулсан бөгөөд олон байгууллагын төлөөлөл, тэдгээрийн явцуу эрх ашиг, сонирхол зэрэг нь Гүйцэтгэгч тодрох үйл явцыг сунжруулж байв . Энэ нь буцалтгүй тусламжийг үр ашигтайгаар, цаг тухайд нь ашиглах, барилгын ажлын улиралд багтаан ажлыг эхлэх, дуусгахад хүндрэл учруулж байв. 5. Бодлого тодорхойлогч болон хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу, мэдээллийн нэгдсэн сан дутмаг, ажил үүргийн хуваарийн давхардал,

	<p>хотын судалгааанд шаардагдах үндсэн материалыг өгөхдөө үнж хөлс нэхэх зэрэг олон сул талууд нь Мастер төлөвлөгөө хийж байгаа байгууллага болон бусад ижил салбарын төслүүдийн үйл ажиллагаанд хүнрэл учруулж, төслийн үйл явцыг саармагжуулж, мухардмал байдалд оруулж байв.</p> <p>6. Мөн иргэдийн оролцоотойгоор олон нийтийн байгууллага байгуулан тэр байгууллагаараа дамжуулан бэрхшээлтэй асуудлаа шийддэг практик Монголд хараахан дэлгэрээгүй байгаа нь энэ чиглэлийн төслийг хэрэгжүүлэхээр оролдож байгаа ТУН-ийн хувьд бас л шинэлэг байв. Иймээс ТУН-ийн ажилтнуудыг зохих сургалтанд хамруулах нь төсөл эхлэх шатанд шаардлагатай байна.</p> <p>7. Урьдчилсан зураг төслөөр тодорхойлогдсон усан хангамжийн барилга байгууламжид шаардагдаж байгаа газрууд нь хэвээр хадгалагдаж чадахгүй, айл өрх албан байгууллагууд эзэлсээр байна. Нүүлгэн суурьшуулах, хашаа татах айл өрхийн тоо судалгаагаар 48 байсан бол ажлын зургийн шатанд 370 болтлоо өсөөд байна. 2006 онд барилгын ажил эхлэхэд энэ тоо хэд болж өсөхийг хэлж мэдэхгүй бөгөөд эдгээрийг дагаад Нүүлгэн шилжүүлэх зардал өсч хотын санхүүд хүндээр тусахад хүрч байна.</p>
<p>2006 онд хийхээр төлөвлөж байгаа ажил</p>	<p>1. УБ хотын НААС II төслийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Шугам хоолой, хаалт арматурын ханган нийлүүлэх тендерийг зарлаж, гүйцэтгэгчийг тодруулна. • Баянхошуу гэр хорооллын шугамын барилгын ажлыг эхлүүлнэ. • 10 машины гаражийн барилгыг барьж, ашиглалтанд оруулна. • Наран, Улиастайн гэр хороололд УТБ-ууд барина. • Баруун дүүргийн насосны станцын ажлыг эхлүүлнэ. <p>2. Голландын буцалтгүй тусламжаар хийгдэх ажлууд</p> <ul style="list-style-type: none"> • Толгойтын далан сувгийн үлдэгдэл хэсгийн тендрийг зарлаж иж бүрнээр нь ашиглалтад өгнө • Сонгинохайрхан дүүргийн 12-р хорооны 580м замын ажил, гүүрийн барилгыг ашиглалтад өгнө. • Хан-уул дүүргийн 5-р хороонд баригдаж байгаа Халуун усны барилгын ажлыг дуусгаж Нийслэлд хүлээлгэн өгнө. • Сэлбийн голын үерийн хамгаалалтын далан сувгийг дуусган ашиглалтад өгнө.

	<p>3.Японы Нийгмийн хөгжлийн сангийн хүрээнд</p> <ul style="list-style-type: none">• Иргэдийн оролцоотойгоор орчноо хөгжүүлэх төслийн Зөвлөхийн багийг тодруулж гаргасан гарын авлага, удирдамжийн дагуу иргэдтэй ажиллах ажлыг эхэлнэ.• Иргэдийн өөрсдийн үүсгэл санаачлага дээр тулгуурласан ТББ-уудыг байгуулна.• Иргэдийн өөрсдийн гаргасан төлөвлөгөөн дээр үндэслэсэн жижиг ажлуудыг төслөөс санхүүжүүлж 10%-ийг дүүргээс, 10%-д нь иргэдийн хөдөлмөрийг оролцуулах замаар санхүүжүүлнэ. <p>4. Францын Улаанбаатар хотын цэвэр, бохир усны мастер төлөвлөгөө боловсруулах төсөл</p> <ul style="list-style-type: none">• Дунд шатны тайлан 1-р сард гарна• Эцсийн тайлан 2-р сард гарна.• Цэвэр, бохир усны мастер төлөвлөгөө боловсруулагдаж, холбогдох байгууллагаас зөвшөөрөл авна. <p>5. Хотын санхүү, хүний нөөцийн удирдлагыг сайжруулах ажлын хүрээнд</p> <ul style="list-style-type: none">• Зөвлөх компанийг 2 сард тодруулна• Үйл ажиллагааны тайлангаа тавина.• Зөвлөх компаний үйл ажиллагаа хэрэгжиж дуусна.
--	--

Тайлан бичсэн: ТУН-ийн менежер-инженер

Д.Цэндсүрэн